

Аудитын тайлан

Аудитын код: САГ-2018/9/СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Аудитор Б.Долгоржав
Утас: 260512 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn

Гэрээт аудитор Э.Гансүх
Гэрээт аудитор Ж.Нямцэцэг

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	3
2.5	Дотоод хяналт	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	4
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
2.9.1	Урьдчилж төлсөн зардлын талаар	5
2.9.2	Бараа материалын талаар.....	5
2.9.3	Хөрөнгийн зарцуулалтын талаар.....	5
2.9.4	Эрх шилжүүлэх талаар.....	6
2.9.5	Санхүүгийн баримт, тайлангийн талаар.....	6
2.9.6	Эрүүл мэндийг дэмжих сангийн удирдах зөвлөлийн талаар	7
2.9.7	Шилэн дансны талаар	7
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	7
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	7
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	8
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал	9
3.1	Бараа материалын талаар	10
3.2	Эрх шилжүүлэх талаар	11
3.3	Эрүүл мэндийг дэмжих сангийн удирдах зөвлөлийн талаар	12
3.4	Шилэн дансны талаар.....	13
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	14
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ГАНЦЭЦЭГ ТАНАА

2018.03.23 № 06/824
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4-д заасны дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлэгдсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110.10.10.20\Bichig_Kherlegjavsan_Bichig\2018\03\20180323\040600

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ


071504

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Ганцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд бараа материалыг тооцооны дансанд бүртгэх, ажил гүйцэтгүүлэх гэрээнд гарын үсэг зурах эрхийг шилжүүлэх, шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4-д заасны дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитыг 2018 оны 3 дугаар сарын 05-наас 2018 оны 3 дугаар сарын 23-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Сангийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Долгоржав, гэрээт аудитор Э.Гансүх, Ж.Нямцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Эрүүл мэндийн яамны 2018 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 2/777 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрүүл мэндийг дэмжих сан санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай, Эрүүл мэндийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.


Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.41, 21⁸ дүгээр зүйлийн 21⁸.1.4, Засгийн газрын 2017 оны “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм, сангийн хөрөнгийг зарцуулах журам” батлах тухай 82 дугаар тогтоолыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/154 дугаар тушаалаар Эрүүл мэндийг дэмжих сангийн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталж, 2017 оны 6 дугаар сараас үйл ажиллагааг нь эхлүүлсэн байна.

Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журамд:

Эрүүл мэндийг дэмжих сан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд зааснаар сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг хянаж тайлагнах ба хөрөнгийг зарцуулах журмын дагуу доорх арга хэмжээг санхүүжүүлнэ. Үүнд:

- халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх;
- халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
- орчны эрүүл мэндийг хамгаалах;
- осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх;
- сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх;
- эмийн зохистой хэрэглээ;
- эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх.
- нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй болгох чиглэлээр хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын үр дүнтэй санаачилга, төсөл, хөтөлбөрийг дэмжих, урамшуулах
- нийгмийн эрүүл мэнд, анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухааны дэвшилтэт технологийг эзэмшүүлэх зорилгоор эмнэлгийн мэргэжилтнийг гадаадад сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг дэмжих.

Тус сан хүн амыг эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, хууль



нөлөөллийг хүргэж, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл аж төрөх ёсыг сурталчилах, орчныг бүрдүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагааг зохион байгуулахад зорилгоо чиглүүлэн ажиллах үүрэгтэй байна.

Тус сангийн удирдах зөвлөл орон тооны бус 11 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд сангийн өдөр тутмын үйл ажиллагааг тус яамны нийгмийн эрүүл мэндийн газар хариуцан гүйцэтгэдэг байна.

Тус сангийн 2017 оны төсвийг Эрүүл мэндийн яамны Төрийн сангаас олгож байна.

Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 - 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Эрүүл мэндийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 19 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Эрүүл мэндийг дэмжих сан тайлант хугацаанд төлбөр тооцоог нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програмаар гүйцэтгэж, санхүүгийн тайланг “Axplorer v3.0” програмаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрүүл мэндийг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад сангийн хөрөнгийг санхүүгийн үйл ажиллагаатайгаа уялдуулалгүй төлөвлөж хуваарилсан нь

01

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилт хяналтгүй явагдах нөхцлийг бүрдүүлж байгаад дотоод хяналт маш хангалтгүй байна гэж үзлээ.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагаанд зориулж 2,970.0 сая төгрөг батлагдсанаар тус сангийн удирдах зөвлөлийн 2017 оны 1 дүгээр хуралдаанаар зарцуулалтын хуваарийг хийсэн ба 2, 3 дугаар хуралдаанаар хуваарьт өөрчлөлтийг хийж хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант онд сангийн хөрөнгийн гүйцэтгэлээр 2,967.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Сангийн хөрөнгийн зарцуулалтын хуваарийг гүйцэтгэлтэй харьцуулбал:
/төгрөгөөр/

№	Зардлын нэр	Санхүүжилтийн хуваарилалтын дүн	Зарцуулалтын дүн
1	Нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн төсөл, арга хэмжээ	428,800,000.0	428,759,456.0
2	Нийгмийн эрүүл мэнд, анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухааны чиглэлээр гадаад орны туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх сургалт	87,634,450.0	87,634,459.2
3	Нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах үйл ажиллагааг явуулах	438,615,550.0	416,415,550.0
4	2017 оныг "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил" болгон зарласан үйл ажиллагааны хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газарт эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт сурталчилгааны үйл ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжүүлэх	252,000,000.0	2,034,766,860.0
5	Өрхийн эрүүл мэндийн төвд халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжүүлэх, гадаад сургалтад хамруулах	1,762,950,000.0	
Нийт дүн		2,970,000,000.0	2,967,576,325.2


Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийг дэмжих сан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах шаардлагатай санхүүгийн ажил гүйлгээтэй холбоотой мэдээллийг шилэн дансаны вэб сайтад байршуулж ажиллаагүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 19 нарийвчилсан горим, зорилт гүйцэтгэв.



Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Урьдчилж төлсөн зардлын талаар

Эрүүл мэндийг дэмжих сангаас мэдээлэл, сурталчилгаа хийлгэх гэрээний дагуу 170.6 сая төгрөгийг олгосноос 24.8 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэж тайлагнасан, 145.8 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, тайлагнаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Тохиолдсон байх" гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д заасны дагуу санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

2.9.2 Бараа материалын талаар

Тус сангийн хөрөнгөөр бэлтгэсэн материалын орлого зарлагын гүйлгээг бараа материалын дансаар дамжуулан бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д зааснаар "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө", Сангийн сайдын 2008 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 17 дахь заалтыг зөрчсөн, мөн санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Толилуулга ба тодруулга" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Иймд цаашид алдааг давтахгүй ажиллах талаар зөвлөмж өгөх.

2.9.3 Хөрөнгийн зарцуулалтын талаар

Сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөс төсөл хэрэгжүүлэхээр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвлэлийн цех, мэдээллийн студи байгуулахад 180.1 сая, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгө бэлтгэхэд 186.1 сая төгрөг, нийт 366.2 сая төгрөгийг хөрөнгө худалдан авч зориулалт бус зарцуулсан байна.

Мөн 13.1 сая төгрөгийг цахилгаан, дулаан, ус, нүүрс, НДШ, хандив гэх мэт урсгал зардалд зориулалт бус зарцуулсан. Эдгээр нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.4-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ" ба 2017 оны 10-р сарын 13-ны 10/ОУ-17/01 дугаар тушаалын 1.1-д "Энэ хуулийн 21⁸.1-д заасан сангийн хөрөнгийг дараах чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, хууль" гэсэн зориулалттай зарцуулна" гэсэн зөвлөмж өгөх.

нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна", мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс үндсэн хөрөнгийг Эрүүл мэндийн сайдын багцад шилжүүлэн авах, хөрөнгийг зориулалт бус зарцуулахгүй байх **албан шаардлага** хүргүүлэх.

Тайлант онд гадаад томилолтын зардлын төсвийг валютаар олгохдоо Арилжааны банкны ханшаар тооцож олгосон, VIP-ийн үйлчилгээ визийн хураамжийн нийт 3.1 сая төгрөгийг Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалыг зөрчин илүү олгосон, анхан шатны баримтын бүрдэлгүй, гүйцэтгэлийн тайлан гаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д зааснаар "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтууд, Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан "Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" гэсэн тушаалыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Хэмжилт" батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтын зардлыг тооцож олгохдоо Сангийн сайдын тушаалыг мөрдөж ажиллах, алдааг давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэх.

2.9.4 Эрх шилжүүлэх талаар

Засгийн газрын 2017 оны 82 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журам"-ын 4.6-д "Сангаас санхүүжилт авахаар шалгарсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байгуулна" гэж заасныг зөрчин хэвлэл мэдээллийн 12 хуулийн этгээдтэй байгуулсан 144.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээнд Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурсан нь санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээ байгуулах, хөрөнгө захиран зарцуулахдаа холбогдох тогтоолыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх.

2.9.5 Санхүүгийн баримт, тайлангийн талаар

Сангийн удирдах ажилтнуудын хөрөнгийн зарцуулалт болон нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, архивын нэгж болгон бэлтгээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5-д "хариуцлагатай байх" гэсэн заалтууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Төрийн аудитын байгууллага, түүний ажилчид бүрэн эрхээ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
САНАЛ ДҮГНЭЛТ

хэрэгжүүлэхэд шаардагдах аливаа мэдээллийг бүрэн хэмжээгээр, чөлөөтэй, шуурхай авах эрхтэй. Энэ хуулийн 15.1-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх", "Тохиолдсон байх", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримт бүрдүүлэлт болон архивын нэгж болгон цэгцлэхийг холбогдох эрх зүйн актын дагуу хэрэгжүүлж ажиллах, Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалтыг үндэслэн тооцооны нягтлан бодогчид хариуцлага тооцох **албан шаардлага** хүргүүлэх.

2.9.6 Эрүүл мэндийг дэмжих сангийн удирдах зөвлөлийн талаар

Сангийн зөвлөл 2017 оны санхүүжилтийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁸ дүгээр зүйлийн 21⁸.2-д заасны дагуу ангилж хуваарилаагүй нь хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Хэмжилт", "Иж бүрэн байх", "Тохиолдсон байх", гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2017 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан "ЭМДС-ийн дүрэм, сангийн хөрөнгийг зарцуулах журам"-ын дагуу төлөвлөлт, төсөл хөтөлбөрт суурилан санхүүжилтийг оновчтой зөв хуваарилж байх талаар зөвлөмж өгөх.

2.9.7 Шилэн дансны талаар

Шилэн дансны хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтийг шалгахад тухайн жилийн батлагдсан төсөв, төсвийн хөрөнгийн зарцуулалт, хэмнэлт хэтрэлтийн шалтгааны тайлбар, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээний хэсэгт санхүүжилт болон зарцуулалтын гүйлгээ зэрэг мэдээллийг вэб сайтад байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Энэ нь аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдэл, Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д "Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна" гэж заасныг зөрчсөн тул зөвлөмж өгөх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ


Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд болон өрхийн эмнэлэгт Эрүүл мэндийг дэмжих сангаас олгосон санхүүжилтийн зарцуулалтанд тавих хяналт, тайлагнал, үр дүнг тооцох тогтолцоо хангалтгүй байгаа нь анхаарал татахуйц байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 672.2 сая төгрөгийн өлдөөн үзэж байсан ба 145.8 сая төгрөгийн алдааг залруулж, 513.3 сая төгрөгийн материаллаг бус зөрчилд



албан шаардлага хүргүүлэх, алдаа зөрчлийг арилгах 144.0 сая төгрөгийн зөвлөмж өгөв.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2016 онд Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагаа явагдаагүй тул санхүүгийн тайланд аудит хийгдээгүй байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Материаллаг байдлыг төлөвлөлтийн үед 2017 оны нийт зарцуулалтын 1.0 хувь буюу 29.7 сая төгрөгөөр тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үед 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлага 2,967.6 сая төгрөгийн 1 хувийн 29.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

2.15 Аудитын үр өгөөжийн талаар

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 528.2 сая төгрөгийн санхүүгийн, 144.0 сая төгрөгийн санхүүгийн бус, нийт 672.2 сая төгрөгийн, мөн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх удирдах зөвлөлийн шийдвэрт гарах үр өгөөжийг тооцож аудитын “Маягт УАГ 1120” бүртгэлд бүртгэлээ.

2.16 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Эрүүл мэндийг дэмжих сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 БАРАА МАТЕРИАЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Эрүүл мэндийн дэмжих сангийн хөрөнгөөр бэлтгэсэн материалын орлого зарлагын гүйлгээг бараа материалын дансаар дамжуулан бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д зааснаар "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Сангийн сайдын 2008 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 17-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн аудитын "Тохиолдсон байх", "Толилуулга ба тодруулга" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Иймд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, Сангийн сайдын 2008 оны 388 дугаар тушаал хэрэгжүүлж, цаашид алдааг давтахгүй ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.2 ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Засгийн газрын 2017 оны 82 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журам"-ын 4.6-д "Сангаас санхүүжилт авахаар шалгарсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байгуулна" гэж заасныг зөрчин хэвлэл мэдээллийн 12 хуулийн этгээдтэй байгуулсан 144.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээнд Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурсан нь санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн хөрөнгөөр гэрээ байгуулах, хөрөнгө захиран зарцуулахдаа холбогдох тогтоолыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Үргүй зардал гаргах, санхүүгийн сахилга бат алдагдах;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



**3.3 ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАЛААР**

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Эрүүл мэндийг дэмжих сангийн зөвлөл 2017 оны санхүүжилтийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁸ дүгээр зүйлийн 21⁸.2-д заасны дагуу ангилж хуваарилаагүй нь хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Хэмжилт", "Иж бүрэн байх", "Тохиолдсон байх", гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Засгийн газрын 2017 оны 82 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм", "Сангийн хөрөнгийг зарцуулах журам"-ын дагуу төлөвлөлт, төсөл хөтөлбөрт суурилан санхүүжилтийг оновчтой зөв хуваарилж байх талаар зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, санхүүгийн сахилга бат алдагдах;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.4 Шилэн дансны талаар**Тэргүүлэх ач холбогдол №3****ҮАГ-ын ажиглалт**

Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг шалгахад тухайн жилийн батлагдсан төсөв, төсвийн хөрөнгийн зарцуулалт, хэмнэлт хэтрэлтийн шалтгааны тайлбар, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээний хэсэгт санхүүжилт болон зарцуулалтын гүйлгээ зэрэг мэдээллийг вэб сайтад байршуулаагүй байна. Энэ нь аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д "Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна" гэж заасныг зөрчсөн тул зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Хууль хэрэгжихгүй байх, ажлын хариуцлага алдагдах;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.0	146,800,000.00
33	АВЛАГА	0.0	1,000,000.00
335	Бусад авлага	0.0	1,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	0.0	1,000,000.00
34	УРЬДЧИЛГАА	0.0	145,800,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	0.0	145,800,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН II	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.0	146,800,000.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР IV	0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН V	0.0	146,800,000.00
51	Засгийн газрын хувь оролцоо	0.0	146,800,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	0.0	146,800,000.00
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	146,800,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.0	146,800,000.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.0	2,971,000,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.0	1,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.0	1,000,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	1,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	1,000,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.0	2,970,000,000.00
1310	Улсын төсвөөс	0.0	2,970,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.0	2,970,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.0	2,824,200,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.0	2,824,200,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.0	2,821,776,325.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	2,821,776,325.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	2,821,776,325.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	2,423,674.80
213403	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	2,423,674.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	2,423,674.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	0.0	146,800,000.00
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (4)	0.0	0.0
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (5)	0.0	0.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (6)=(3)+(4)-(5)	0.0	146,800,000.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.0	0.0	0.0	0.0
C07	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	0.0	0.0
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
D08	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	146,800,000.00	146,800,000.00
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.0	0.0	146,800,000.00	146,800,000.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.0	2,970,000,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.0	2,970,000,000.00
1310	Улсын төсвөөс	0.0	2,970,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.0	2,970,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.0	2,970,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.0	2,970,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.0	2,967,576,325.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	2,967,576,325.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	2,967,576,325.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	2,423,674.80
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	2,423,674.80
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	2,423,674.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.0	0.0
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.0	0.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.0	0.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.0	0.0
14	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.0	0.0
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (7)	0.0	0.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.0	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0	0.0	
71601	Нийгмийн эрүүл мэнд	2,970,000,000.00	2,967,576,325.20	2,423,674.80	99.9%
81605	Эрүүл мэндийг дэмжих	2,970,000,000.00	2,967,576,325.20	2,423,674.80	99.9%
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,970,000,000.00	2,967,576,325.20	2,423,674.80	99.9%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,970,000,000.00	2,967,576,325.20	2,423,674.80	99.9%
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,970,000,000.00	2,967,576,325.20	2,423,674.80	99.9%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,970,000,000.00	2,967,576,325.20	2,423,674.80	99.9%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,970,000,000.00	2,967,576,325.20	2,423,674.80	99.9%
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,970,000,000.00	2,967,576,325.20	2,423,674.80	99.9%
1310	Улсын төсвөөс санхүүжих	2,970,000,000.00	2,967,576,325.20	2,423,674.80	99.9%
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,970,000,000.00	2,967,576,325.20	2,423,674.80	99.9%
5	Мөнгөн хөрөнгий эцсийн үлдэгдэл	0.0	0.0	0.0	

